



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Шагнаж урамшуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, 43.2.2 дахь заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.14 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Алтан гадас одон”-оор шагнуулсан Түлш дамжуулах цехийн дарга Донхооны Түвшинзаяад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу 880,000 (Найман зуун наян мянга)-н төгрөгөөр шагнаж, урамшуулсугай.

2. Д.Түвшинзаяад 880,000 (Найман зуун наян мянга)-н төгрөгийн мөнгөн урамшууллыг тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ